



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 1/41

Мандалговь

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг
даатгалд хамруулах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг гэнэтийн ослын эрсдэл болон бүх төрлийн хүчирхийллийн эрсдэлийг багтаасан даатгалын цогц үйлчилгээнд хамруулсугай.

2. Даатгалын үйл ажиллагаанд шаардагдах 2.600.000 (Хоёр сая зургаан зуу мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Хүүхдүүдийг даатгалд хамруулах ажлыг 2020 оны 06 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд зохион байгуулж тайланг даргын дэргэдэх зөвлөлд 2020 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Х.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

9115

481190081